




**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
БАЯН- ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн**



**ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУД ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ
ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.**

Баян-Өлгий аймаг, Өлгий сум

АГУУЛГА	Товчилсон үгийн тайлбар3
Тайланг бэлтгэсэн:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4-5
Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар	Бүлэг: 1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх талаар..... 6-18
Дарга,Тэргүүлэх аудитор М.Хуанган	1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.....6-9
Аудитын менежер Х.Женисбек	1.2 Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.....9-12
Аудитын баг	1.3 Захиргааны хяналтыг хуульд заасан журмын дагуу тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....12-13
Аудитор Д.Назгүл	1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэхэд ажлаа чиглүүлж, ач холбогдол өгч ажилласан байна.....14-16
Аудитор Б.Үүрийнтуяа	1.5 Хууль сахиулах байгууллагууд хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэх, сурталчлах, сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна.....16-18
2017 оны 10 дугаар сар	Бүлэг: 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байгаа эсэх талаар.....19-22
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70422954, 70422930, 70423073 дугаарын утсаар хандана уу.	2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байна..19-20
ХАЯГ: Аймгийн ЗДТГазрын байр,1 дүгээр давхар 110, 112 тоот өрөө	2.2 Төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна..20-21
	2.3 Сумуудын ГХУСАЗСЗ-үүдийн үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байна.....21-22
	Бүлэг: 3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэх талаар.....23-27
	3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгө хуулинд заасан хувь хэмжээнд төлөвлөгдөөгүй байна.....23-24
	3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд батлагдсан төсөв нь ГХУСТХуулийн 19.3-т заасан заалтуудтай нийцэхгүй байна.....24-25
	3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгөөс 23,9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.....25-26
	3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.....26-27
	Дүгнэлт.....28
	Зөвлөмж..... 29
	Холбогдох байгууллагын санал.....30
	Баталгаажуулсан гарын үсэг.....31

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт:

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж санал, зөвлөмж өгөх, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Хамрах хүрээ:

Энэхүү аудитад аймгийн ИТХ, аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газар болон бусад холбогдох төрийн байгууллагуудын 2015-2017 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримт материал, ажлын төлөвлөгөө, тооцоо судалгаа бусад холбогдох баримтуудыг хамруулж, хэрэгжүүлэв.

Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материалд үндэслэн хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, ажлын тайлан, баримт материалд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Назгүл ахалж, аудитор Б.Үүрийнтуяа нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг 2016 оны 10 дугаар сарын 03-наас 10 дугаар сарын 20-ны хооронд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж, аудитын тайланг бэлтгэв. Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргасан болно.

Асуудлын талаар товч мэдээлэл:

ГХУСТХ-ийн 16.1-д заасны дагуу аймгийн ИТХ-ын дэргэд ИТХ-ын даргаар толгойлуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус зохицуулах зөвлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг байна.

Баян-Өлгий аймгийн аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСА33-ийн 2015-2017 оны ГХУС үйл ажиллагааны зардалд нийтдээ 60,0 сая төгрөгийн төсөв батлагдаж, зарцуулагдсан байна.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам
- Цагдаагийн албаны тухай хууль
- Прокурорын байгууллагын тухай хууль
- Прокурорын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

Бүлэг 1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Бүлэг 1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх талаар.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл нь:

- “Гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох” явдал ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлэх цогцолбор арга хэмжээ юм.

Цагдаагийн албаны тухай хуулинд Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн талаар 10 дугаар зүйлийн 10.1.1-д:

- Цагдаагийн байгууллага нь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах” бүрэн эрхтэй гэж заажээ.

ГХУСТХ-ийн 20 дугаар зүйлд зааснаар:

- Шүүх, Прокурор, Цагдаагийн болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, эрх бүхий бусад байгууллага нь гэмт хэргийн тоо бүртгэл хөтөлж, гэмт хэргийн мэдээллийг боловсруулж, дүн шийнжилгээ хийснээр гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох зорилгоор гэмт хэргийн мэдээлэл цуглуулах, боловсруулах үйл ажиллагааг хийх ёстой.

Улсын Ерөнхий Прокурорын 2015 оны А/121 дугаар тушаалаар баталсан:

- “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”

1.1. Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүрэг хэрхэн хэрэгжиж байгаа талаар.

Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиг үүргийн хэрэгжилтийн талаар шалгаж үзэхэд: аймгийн Цагдаагийн газар эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын мэдээг сар бүр гаргаж, гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгахад ажлаа чиглүүлж ажилласан байна.


Аймгийн ГХУСАЗЗ нь хууль сахиулах байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд гарч байгаа гэмт хэргийн талаар мэдээллийг хагас, бүтэн жилээр дүгнэж, нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар авах арга хэмжээг төлөвлөж ажилласан байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийг сумуудаар ангилж үзэхэд дараах байдалтай байна. /Хүснэгт №1/

Хүснэгт №1

№	Сумууд	Нийт гарсан гэмт хэрэг							
		2015 он	2016 он	Зөрүү	Өсөлт, бууралтын хувь	2016.06.31	2017.06.30	Зөрүү	Өсөлт, бууралтын хувь
1	Алтай сум	16	12	4	-25.0	7	5	2	-28.6
2	Алтанцөгц сум	7	13	-6	85.7	6	1	5	-83.3
3	Баяннуур сум	10	23	-13	130.0	13	6	7	-53.8
4	Бугат сум	10	16	-6	60.0	5	7	-2	40.0
5	Буянт сум	14	12	2	-14.3	3	7	-4	133.3
6	Булган сум	4	4	0	0.0	1	1	0	0.0
7	Дэлүүн сум	7	7	0	0.0	5	5	0	0.0
8	Улаанхус сум	18	25	-7	38.9	16	4	12	-75.0
9	Ногооннуур сум	29	15	14	-48.3	8	13	-5	62.5
10	Цагааннуур сум	16	12	4	-25.0	0	1	-1	
11	Сагсай сум	8	11	-3	37.5	2	5	-3	150.0
12	Цэнгэл сум	22	19	3	-13.6	12	16	-4	33.3
13	Толбо сум	14	5	9	-64.3	1	4	-3	300.0
14	Өлгий сум	120	107	13	-10.8	56	75	-19	33.9
	Бүгд	295	281	14	-4.7	135	150	-15	11.1

2015, 2016 он болон 2016 оны 6 дугаар сарын 30, 2017 оны 6 дугаар сарын 30-ны байдлаарх гэмт хэргийн өсөлт, бууралтыг графикаар харьцуулж харуулвал:



2015, 2016 он



2016.06.30, 2017.06.30

2016 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийг 2015 онтой харьцуулахад 14-өөр буюу 4,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2016 онд Алтанцөгц, Баяннуур, Бугат, Улаанхус, Сагсай зэрэг 5 суманд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оноос 37,5-130 хувиар өссөн байна.

Аймгийн ГХУСАЗЗ-өөс энэ байдалд анхаарал хандуулж, гэмт хэргийн гаралтын нөхцөл байдал, шалтгааныг тогтоох зорилгоор 2016 оны ажлын төлөвлөгөөнд дээрх гэмт хэргийн гаралт өндөр сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалгаж, заавар зөвлөгөө өгөх асуудлыг төлөвлөгөөнд тусгасан байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээг 2016 оны мөн үетэй харьцуулж үзэхэд 15-аар буюу 11,1 хувиар гэмт хэргийн гаралт өссөн дүнтэй байна.

Сумуудаар авч үзвэл: Бугат, Буянт, Ногооннуур, Сагсай, Цэнгэл, Толбо, Өлгий зэрэг 7 сумын гэмт хэргийн гаралтын тоо 40 хувиас 3 дахин өссөн

үзүүлэлттэй байна. Өмнөх онд шалгалт хийгдсэн 4 сумын гэмт хэргийн тоо буурсан байна.

Цагдаагийн албаны тухай хуулинд Цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүрэг болох гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн талаар 10 дугаар зүйлийн 10.1.1, ГХУСТХ-ийн 20 дугаар зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлж Цагдаагийн газраас аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлж, таслан зогсоох талаар аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалдай уялдуулан 2015 онд 33, 2016 онд 65, 2017 онд 133 удаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тус тус зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан байна.

Аймгийн Прокурорын газрын “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”-т заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээний дүн дараах байдалтай байна.Үүнд:

-2015 онд эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 19 удаа судалгаа хийж, ГХУС чиглэлээр 2 удаагийн шалгалтанд оролцож, хууль сурталчилах талаар 33 удаа зөвлөгөөн, ярилцлага, мэдээлэл хийж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 22 удаа сурталчилгаа явуулж, 38 мэдэгдэл бичсэнээс 28 мэдэгдлийн хариуг тооцож ажилласан байна.

-2016 онд ГХУС чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 9 удаа сурталчилгаа, 24 удаа хамтарсан болон дангаараа яриа таниулга, дангаараа 11 удаагийн шалгалт, 12 удаа судалгаа тус тус хийж, 36 мэдэгдэл бичиж үүнээс 23 мэдэгдлийн хариуг авч ажиллажээ.

-2017 онд ГХУС чиг үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр 5 удаа нэвтрүүлэг, 10 удаа яриа танилцуулга, 2 удаа шалгалт, судалгаа 7-г тус тус хийж, 13 мэдэгдэл бичсэнээс 12 мэдэгдлийн биелэлтийг хангуулж ажиллажээ.

ШШГА-наас 2017 онд ГХУС хүрээнд өөрийн дотооддоо ГХУС зорилгоор хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж, өдөр тутмын 158 үзлэг, харуул хамгаалалтын бие бүрэлдэхүүний хүчээр гэнэтийн үзлэг, нэгжлэгийг 45 удаа, нийт 203 удаа үзлэг, нэгжлэг хийсэн байна.

Аймгийн ГХУСАЗЗ нь бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг гэмт хэргийн төрөл, үйлдэгдсэн газар, үйлдэгдсэн гараг, цаг хугацаа, гэмт хэрэгт холбогдогч зэрэг олон хүчин зүйлийн хамт судалж үзээд дараах дүгнэлтийг хийсэн байна.

Гэмт хэргийн төрлөөр авч үзэхэд: бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх, хулгайлах, бусдын бие махбодод гэмтэл учруулах, тээврийн хэрэгсэлийн ашиглалтын журам зөрчих зэрэг гэмт хэргүүд өссөн дүнтэй гарсан байна.

Гэмт хэрэг гарч байгаа орчин нөхцөлийг судалж үзэхэд: гэр орон сууцанд болон төрийн бус байгууллагад гарсан гэмт хэрэг өссөн дүнтэй байна.

Ерөнхий шалтгаан нөхцөл нь:

- Ажилгүйдэл, ядуурал/орлогын эх үүсвэргүй/
- Хүн амын хэт төвлөрөл

- Иргэдийн боловсролын түвшин доогуур
- Ёс суртахууны төлөвшил хангалтгүй
- Архидалт
- Бусдын эрхийг үл хүндэтгэх явдал нийтлэг болсон
- Хүмүүсийн стресс, бухимдал нэмэгдсэн
- Хууль тогтоомжын хэрэгжилт хангалтгүй гэж үзсэн байна.

Тодорхой шалтгаан нөхцөл нь:

- Хувь хүмүүсийн ухамсар, ёс зүйн төлөвшил
- Хүмүүс бие биеэ үл хүндэтгэх явдал
- Эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаггүй
- Иргэдийн сонор, сэрэмж, анхаарал болгоомжгүй, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал
- Жолооч нарын ур чадвар, хууль, дүрмийн мэдлэг муу
- Замын орчин, нөхцөл стандартын шаардлага хангаагүй
- Хувь хүний стресс, бухимдал
- Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэггүй байдал
- Ахуйн хэрэглээний архидалт гэж тодорхойлсон байна.

Хүчин зүйл нь:

- Нийгмийн ёс суртахууны төлөвшил
- Хувь хүний хүмүүжил, хүнлэг харилцаа
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хандлага, сэтгэлгээ иргэдийн дунд төлөвшөөгүй байдал
- Иргэдийн орлого буурсанаас иргэд амар хялбар аргаар мөнгө олох сонирхолтой болсон
- Иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ахуйн хүрээнд архидан согтуурах явдал их байгаатай холботой гэж үзсэн байна.

1.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж байгаа эсэх талаар.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгаж, урьдчилан сэргийлэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээний талаар :

-2015 онд аймгийн ГХУСАЗЗ 7 чиглэлээр 35 ажил, Цагдаагийн газар 7 чиглэлээр 35 ажил, Прокурорын газар 2 чиглэлээр 6 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

-2016 онд аймгийн ГХУСАЗЗ 2 чиглэлээр 25 ажил, Цагдаагийн газар 9 чиглэлээр 27 ажил, Прокурорын газар 1 чиглэлээр 8 ажил төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

-2017 онд аймгийн ГХУСАЗЗ 2 чиглэлээр 32 ажил, Цагдаагийн газар 8 чиглэлээр 35 ажил, Прокурорын газар 1 чиглэлээр 5 ажил төлөвлөж, эхний хагас жилийн байдлаар төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнасан байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгаж, урьдчилан сэргийлэх нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээний талаар 2015-2017 онд давхардсан тоогоор 22 чиглэлийн ажлыг төлөвлөж, хэрэгжүүлжээ.

2015-2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ГХУСАЗСЗ болон Цагдаагийн газар, Прокурорын газрын төлөвлөж хэрэгжүүлсэн арга хэмжээг хүснэгтээр нэгтгэн харуулвал:

Хүснэгт
№2

№	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн арга хэмжээний чиглэл	Аймгийн ГХУСАЗСЗ			Аймгийн Цагдаагийн газар			Аймгийн Прокурорын газар		
		2015 он	2016 он	2017 он	2015 он	2016 он	2017 он	2015 он	2016 он	2017 он
		Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ	Төлөвлөсөн арга хэмжээ
1	Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх	6			3					
2	Хар тамхи мансууруулах бодисын хор уршиг, түүнээс урьдчилан	4			7					
3	Замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс	5			5		7	1		
4	Хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан				5	1				
5	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан				6	3				
6	Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх				6	3	5			
7	Нийгмийн ажилтан, сургагч багш нарыг бэлтгэх				3					
8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлого боловсруулах	10	13	13		3		5	8	5
9	Мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл бодистой холбоотой гэмт хэргээс					1				
10	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах ажлын уялдааг хангах хүрээнд					4				
11	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх	2				2				
12	Мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх					3				
13	Олон нийт-Цагдаагийн хамтын ажиллагааны хүрээнд					7				
14	Эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр						4			
15	Нийт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр	5					5			
16	Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх						5			
17	Зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх						3			
18	Гэмт хэрэг үйлдэж болзошгүй сэжигтэй этгээдэд захиргааны хяналт тавих						2			
20	Сургалт, сурталчилгаа, судалгааны чиглэлээр		12				4			
21	Хамтын үйл ажиллагааны талаар /хэвлэл мэдээллийн албуудтай/	3								
22	Зохион байгуулалтын талаар			19						
Бүгд		35	25	32	35	27	35	6	8	5

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд аймгийн ГХУСАЗСЗ төвлөлөөс аймаг, сумын ИТХурал, Засаг дарга, сумдын ГХУСАЗСЗ, аймаг дахь хууль хүчний байгууллагууд, ГБХЗХГазар, МХГ, СХЗХ, олон улсын байгууллага, ТББайгууллагуудтай хамтран ажилласан байна.

ГХУСАЗСЗ 2015-2016 онд гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр Алтай, Алтанцөгц, Баяннуур, Буянт, Сагсай, Улаанхус сумын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, заавар зөвлөгөө өгч, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Жилийн турш “Гэмт хэрэг зөрчилгүй хамт олон” сэдэвт аян зохион байгуулсан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон төрийн албан хаагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдол өгсөн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ, Прокурорын газартай хамтран аймгийн эрүүл мэнд, боловсролын салбарын бүх байгууллага, аймгийн төвийн томоохон аж ахуйн нэгж байгууллагууд, Хилийн цэргийн ангиуд болон Өлгий сумын багуудын иргэд,

худалдаа эрхлэгчид, таксийн жолооч зэрэг 1500 гаруй иргэнийг хамруулсан “Хариуцлага ба гэмт хэрэг” сэдэвт бүх нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, өмнөх оны гэмт хэргийн нөхцөл байдлыг хэлэлцүүлэн дүгнэлт хийж, зарим тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад анхаарч ажилласан байна.

Аймгийн ГХУСАЗЗ болон Тагнуулийн Ерөнхий газрын Баян-Өлгий аймаг дахь газар хамтран 2015 оны 6 дугаар сард аймгийн хэмжээний бүх ААН, байгууллага, оюутан, сурагчдын дунд хар тамхи, мансууруулах бодисийн хор, холбогдлын талаар сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулжээ.

2015 онд Аймгийн ГХУСАЗЗөвлөл, аймгийн Цагдаагийн газар, Дэлхийн зөн-Монгол ОУБ-ын аймаг дахь салбар хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цагдаагийн хүрээний албан хаагчдыг хамруулан баруун бүсийн нэгдсэн сургалт, зөвлөлгөөнийг зохион байгуулсан байна.

2015, 2016 онд Ховд, Говь-Алтай аймагт Цагдаагийн Ерөнхий газар, болон тус аймгуудын ГХУСАЗЗөвлөл, Цагдаагийн газар хамтран зохион байгуулсан “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт баруун бүсийн сургалт, зөвлөгөөнд Цагдаагийн газрын удирдлагууд, тус чиглэлээр ажилладаг цагдаагийн алба хаагчид болон аймгуудын ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дарга, ажилтнууд хамрагдсан байна.

2016 оны 3 дугаар сард аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газар хамтран Монгол улсын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”, болон “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад нь аймгийн ГХУСАЗЗ болон Цагдаагийн байгууллагаас мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах, гэмт хэрэг, зөрчил гарах шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэхэд байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн төвийн бүх ААН, байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.

2016 онд Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, аймгийн ГХУСАЗЗөвлөл, Цагдаагийн газар хамтран “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд инноваци нэвтрүүлэх нь” сэдэвт баруун бүсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн болон Цагдаагийн газруудын алба хаагчдын нэгдсэн эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна.

Хууль зүйн яамны 2016 оны 6/1366 дугаар албан тоотоор ирүүлсэн Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллага, тэдгээрийн урсгалын талаар шалгалт хийх ажлын удирдамжийн дагуу аймгийн Засаг даргын А/199 дугаартай захирамжаар ажлын хэсэг байгуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, шашны байгууллагуудад шалгалт хийж үр дүнг тайлагнасан байна.

Монгол улсын Шадар сайдын 2016 оны 30 дугаар тогтоолоор баталсан “АСЕМ”-ын дээд хэмжээний уулзалтыг угтаж баталсан тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд аймгийн МХГазар, Цагдаагийн газар, ОБГазар болон ТГазрын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу дээрх байгууллагуудын ажилтнуудын хамт тэсрэх бодис ашигладаг 4 аж ахуйн

нэгжүүдэд үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалыг арилгах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг хангуулж ажиллажээ.

ГХУСА33-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасаны дагуу төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж ойн төлөв байдалтай танилцах, Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Амьтны тухай, Байгалийн ургамлын тухай, БОНБУ-ний тухай, Хог хаягдлын тухай, Усны тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, дүрэм, стандартын мөрдөлтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, зөрчлийг бууруулах, сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт болон иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор аймгийн ИТХ-ын Байгаль орчин, боловсрол, соёл спорт, аялал жуулчлалын хороо, ИТХ-ын ГХУСА33, БОАЖГ, МХГ, ЦГ, Ойн ангиудтай хамтран шалгалт зохион байгуулжээ.

Шалгалтанд Алтанцөгц, Баяннуур, Ногооннуур, Бугат сумдын газар нутагт оршин сууж буй айл өрх, иргэд болон үйл ажиллагаа явуулж байгаа ААНБайгууллагууд, байгалийн нөөц баялаг бүхий газрууд, холбогдох байгууллагууд хамрагдсан байна.

Аймгийн ГХУСА33, ГБХЗХГ, Дэлхийн зөн ОУБ-тай хамтран 2017 онд аймгийн хэмжээнд гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн тулгамдсан асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор "Хүүхэд, гэр бүлийн өмнө тулгамдаж буй асуудал түүнийг шийдвэрлэх арга зам, хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох нь" сэдэвт аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг зохион байгуулсан ба чуулганд аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулиудын төлөөлөл 250 хүүхэд оролцсон байна.

1.3. Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт хэрхэн тогтоож байгаа талаар.

2015 онд Монгол Улсын ГХУСТХууль, ЦЕГ-ын даргын 2012 оны 352 дугаар тушаалаар батлагдсан "Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тогтоох", "Тэнсэгдсэн ялтан, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхдэд хяналт тавих" журмуудын хэрэгжилтийг хангаж, улмаар хорих ялаас тэнсэгдсэн, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан, гэмт хэрэг үйлдэж ял хойшлогдсон, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн захиргааны хяналтын хэргийн бүрдүүлэлтийг сайжруулж, мэдээллийн санд бүрэн оруулсан байна.

2015 онд шүүхээс хорих ялыг нь тэнсэн харгалзсан 48, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан 15, ял хойшилсон 3, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 1 бүгд 67 хүнд захиргааны хяналт тогтоож ажиллажээ.

Цагдаагийн газар 2016 онд шүүхээс хорих ялыг нь тэнсэн харгалзсан, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан, ял хойшилсон, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, 5-аас дээш жил хорих ял эдлээд суллагдсан 35 хүнд ГХУСТХуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хяналт тогтоож ажилласан байна.

2016 онд захиргааны хяналтанд байгаа ялтануудаас гэмт хэрэгт холбогдсон хүн гараагүй байна.Цагдаагийн газар нь Прокурорын газартай хамтарч улирал

тутамд захиргааны хяналтанд байгаа хүмүүсийн хувийн хэргийг нэгдсэн байдлаар шалгаж ажилласан байна.

Цагдаагийн газраас 2016 оны 03 дугаар сард “Хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд тавих хяналтыг сайжруулах 45 хоногийн аян”, “Захиргааны хяналтанд байгаа ялтануудад тавих хяналтыг сайжруулах 30 хоногийн аян”, “Тэнсэгдсэн ялтануудад тавих хяналтыг сайжруулах” зэрэг нэг бүрчилсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж, захиргааны хяналтанд байгаа ялтануудад тавих хяналтыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналтыг сайжруулах, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллажээ.

2017 онд шүүхээс хорих ялыг нь тэнсэн харгалзсан, хорих ялаас хугацааны өмнө тэнсэн сулласан, ял хойшилсон, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, 5-аас дээш жил хорих ял эдлээд суллагдсан, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан зэрэг 61 хүнд захиргааны хяналт тогтоож ажилласан байна.

Давхардсан тоогоор захиргааны хяналтанд байгаа 176 хүнтэй биечлэн уулзаж, зөвлөлгөө өгч ажилласан байна.

Тайлант онд захиргааны хяналтанд байгаа ялтануудаас гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, хяналтаас оргон зайлсан тохиолдол гараагүй байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчим”-ыг хангах, тэнсэгдсэн ялтануудад тавих хяналтыг сайжруулах, гэмт хэрэг, зөрчилд дахин холбогдохоос урьдчилан сэргийлэх, Улсын Ерөнхий Прокурор, ЦЕГ-ын даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05, А/09 дүгээр тушаалаар батлагдсан “Тэнсэгдсэн ялтанд хяналт тавих журам”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, захиргааны хяналтын явцад гаргаж буй алдаа дутагдлыг арилгах зорилгоор 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс “Тэнсэгдсэн ялтануудад тавих хяналтыг сайжруулах” нэг бүрчилсэн арга хэмжээг 30 хоногийн хугацаатай зохион байгуулсан байна.

Аймгийн Прокурорын газар Цагдаагийн газартай хамтран 2017 оны 4 дүгээр сард захиргааны хяналтанд байгаа нийт 41 захиргааны хяналтын материалыг шалгаж, шалгалтын хүрээнд “Захиргааны хяналтыг сайжруулах, цаашид анхаарах асуудал” сэдэвт уулзалт зохион байгуулсан байна.

Уулзалтаар аймгийн Прокурор, Цагдаагийн газрын даргаас захиргааны хяналтын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлын талаар хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар үүрэг, чиглэл өгч ажилласан байна.

Шалгалтын дүнгээр захиргааны хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн 7 алба хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг Цагдаагийн газрын даргын тушаалаар 10 хувь бууруулж, хариуцлага тооцожээ.

2017 оны 05 дугаар сард захиргааны хяналтанд байгаа хүмүүсийг нийгэмшүүлэх ажлыг сайжруулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, багийн Засаг дарга нартай хамтран хүмүүжихэд нөлөө үзүүлэх зорилгоор аймгийн төвд захиргааны хяналтанд байгаа этгээдийг хамруулсан сургалтыг зохион байгуулсан байна.

1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг хэрхэн татан оролцуулж байгаа талаар.

2015 онд Цагдаагийн газраас гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг тогтоож, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар 87 мэдэгдэл хүргүүлнээс 79 мэдэгдлийн хариуг хугацаанд бичгээр авч, мэдэгдлийн хариу ирүүлээгүй 4 иргэн, 5 албан тушаалтанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2-т зааснаар 240,0 мянган төгрөгийн торгууль ногдуулж ажиллажээ.

Цагдаагийн газар нь 2016 онд Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, цагдаагийн газрын ажил, үйлчилгээг иргэд, олон нийтэд жигд хүртээмжтэй хүргэх, иргэдийн санал, хүсэлтийг сонсох, гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын цар хүрээг өргөжүүлэх зорилгоор 2016 оны 3, 5 дугаар сард “Нээлттэй өдөр”, 2016 оны 10 дугаар сард “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр” өдөрлөгийг аймгийн төв болон 12 сум, 1 тосгонд тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ба энэ арга хэмжээнд нийт 1529 иргэн, 99 аж ахуйн нэгж байгууллага, давхардсан тоогоор “Өсвөрийн цагдаагийн бүлгэм”-ийн 80 гишүүн оролцсон байна.

Арга хэмжээнд хамрагдсан иргэдэд үйл ажиллагаагаа танилцуулж, үйлчилгээ авахаар ирсэн иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж, талархлын карт гардуулсан байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1.2-т заасан үүргээ хэрэгжүүлж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахад нь мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/08 тоот тушаалаар алба хаагчдад аймгийн төвийн баг, аж ахуйн нэгж байгууллагуудыг хариуцуулсан байна.

Хариуцсан алба хаагч нар 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдөр аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг 82 ААНБайгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж, гэрээний дагуу 43 байгууллагын 7836 хүнд сургалт зохион байгуулсан байна.

Хамтын ажиллагааны хүрээнд 5 байгууллагын 28 ажилтан, алба хаагчийг “Нийтийн эргүүл”-д татан оролцуулсан байна.

2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийн 38 цэгт 49 хяналтын камер, 2 км урттай гудамж талбайд 66 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах, хяналтын төвийг Цагдаагийн газарт төвлөрүүлэн төв серверийн өрөөг тохижуулах ажлыг бүрэн хийж ашиглалтанд оруулсан байна.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа банк, санхүүгийн байгууллагуудын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулж, болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2016 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс “Банк” хэсэгчилсэн арга хэмжээг зохион явуулж, ХААН, Хас, Голомт, Капитрон, Капитал, Төрийн банкны салбаруудад хяналтын камер, дохиоллын систем

суурилагдсан эсэх, харуул, хамгаалалт, аюулгүй байдал нь хэрхэн хангагдсныг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр ХААН, Төрийн банкны салбаруудад албан мэдэгдэл хүргүүлж, зөрчлийг арилгуулсан талаар хариуг авч ажиллажээ.

ЦШСГ, Дулааны станц, Орон нутгийн музей зэрэг онцгой объектуудын харуул хамгаалалт, гэрэлтүүлэг, дохиоллын системийн бүрэн бүтэн байдлыг шалгах зорилгоор “Харуул хамгаалалт” арга хэмжээг 2016 онд нэг сарын хугацаатай зохион явуулсан байна.

2016 онд хяналтын камераар 4 хэрэг, 1286 зөрчил илрүүлж, 1194 зөрчилд 13,1 сая төгрөгийн торгууль ногдуулсан мэдээтэй байна.

2017 оны эхний 9 сарын байдлаар 830 зөрчил илрүүлэн, зөрчлийн нотлох баримтыг хэвлэн гаргаж, зөрчил гаргасан иргэдэд 10,8 сая төгрөгийн торгууль ногдуулж, үйлдэгдсэн 138 гэмт хэргийн нотлох баримт болох дүрс бичлэгийг шүүж, хяналтын камерийн тусламжтайгаар 59 үйлдлийг илрүүлсэн байна.

Цагдаагийн газар 2016 онд нь тус аймагт бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд 126 албан мэдэгдэл, шаардлага хүргүүлсэнээс 123 албан мэдэгдэл, шаардлагын хариуг хугацаанд нь бичгээр авчээ.

Харин мэдэгдэл, шаардлагын дагуу тодорхой ажил зохион байгуулаагүй, хариу ирүүлээгүй, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.2-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй 3 албан тушаалтанд 80,0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан байна.

2017 онд 59 мэдэгдэл, 67 шаардлага хүргүүлж биелэлтийг 100 хувь хангуулсан ба 22 мэдэгдэл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгасан байна.

Цагдаагийн газар 2017 онд аймгийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан:

- 33 удаа ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээ,
- 18 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт,
- 28 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгаа,
- 45 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага,
- 4 удаа өдөрлөг,
- 5 удаагийн уралдаан тэмцээнийг орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулж, эдгээр арга хэмжээнд 5880 хүн хамрагдсан байна.

Дээрхи арга хэмжээнүүдэд төрийн байгууллага 34, төрийн бус байгууллага 3, аж ахуйн нэгж 2, их, дээд сургууль, коллеж, МСҮТ 3, ЕБСургууль 12, Хүүхдийн цэцэрлэг 2 бүгд 53 аж ахуйн нэгж байгууллага оролцож, төрийн болон төрийн бус байгууллагын 1320 ажилтан, 330 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, 340 малчин, 72 оюутан, сургууль завсардсан 6 хүүхэд, 2101 сурагч, 1711 ажилгүй иргэд хамрагдсан байна.

Иргэдийн нийтийн эргүүлд 35 байгууллагын 108 алба хаагч хамрагдаж, 485 иргэн, албан тушаалтан, 259 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж, 95 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 499 хүнд хууль тогтоомжийг сурталчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 267 сэрэмжлүүлэг, зөвлөмж тарааж, 11 зөрчлийг таслан зогсоож, 22 зөрчил илэрүүлсэн байна.

Цагдаагийн газар төрийн 74, төрийн бус 8 байгууллага, 9 аж ахуйн нэгж байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан 5 удаагийн арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажилласан байна.

Цагдаагийн газраас аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа малчдын 82 бүлгэм, 3 хөршийн холбоо, 13 өсвөрийн цагдаагийн бүлгэм, 26 хамтарсан баг, 13 сургуулийн 743 гишүүнтэй “Сургуулийн цагдаа”-г 16 удаа мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллажээ.

2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон 11 иргэнийг аймгийн ГХУСАЗСЗ болон Засаг даргын холбогдох шагналаар, 2 иргэнийг ГХУСАЗСЗ-ийн хүндэт өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан байна.

1.5 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт үр дүнтэй зохион байгуулагдаж байгаа эсэх талаар.

Аймгийн ГХУСАЗСЗ 2015 онд орон нутгийн радио телевизээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 удаагийн сэрэмжлүүлэг, нийтлэл, 3 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, иргэд олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд “Аюулгүй амар амгалан Өлгийчүүдийн төлөө хамтдаа” нэртэй 720 ш сэтгүүлийг хэвлэн гаргаж, иргэд олон нийтэд үнэ төлбөргүй хүргэсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ 2015-2017 онд аймгийн ИТХ-ын www.bayan-olgi.khural.mn вэб сайт, “Баян-Өлгий аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл” фейсбүүк хуудсанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион явуулсан ажил, арга хэмжээний талаар мэдээ, мэдээллийг тогтмол хүргэж ажиллажээ.

2016 онд орон нутгийн радио, телевизээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 35 удаагийн сэрэмжлүүлэг, нийтлэл, 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэж ажилласан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн төвийн Мобикомын 12121 хэрэглэгчдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр масс мессеж илгээсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2, 5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор салбар зөвлөлийн ивээл дор “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт аймгийн нэгдсэн зөвлөгөөнийг 2017 оны 02 дугаар зохион байгуулсан байна.

Зөвлөгөөнд төрийн болон төрийн бус байгууллагуудын алба хаагчид, тус аймагт үйл ажиллагаа явуулж буй жолооны сургуулиуд, албан журмын даатгагчдын холбоо, иргэдийн төлөөлөл оролцжээ.

Цагдаагийн газар нь Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, цагдаагийн байгууллагаас хийж гүйцэтгэсэн ажлыг иргэдэд тайлагнах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор 2016 оны 01 дүгээр сарын 15-наас 02 дугаар сарын 15-ны хооронд “Иргэдээ сонсоё” аяныг зохион байгуулж МСҮТ, Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургууль, Хүүхдийн 11 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид, оюутан, сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, хууль тогтоомжийг сурталчлан, иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан байна.

Аяны хүрээнд 12 сум, 1 тосгоны 513 айл өрхөөр зочилж, 1348 иргэнд хууль тогтоомж сурталчлах, санал хүсэлтийг нь сонсох ажлыг зохион байгуулжээ.

Цагдаагийн газраас 2016 онд “Хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах журам”-ын 242.6.2 дахь заалтын дагуу гэмт хэрэг, зөрчлийн талаар өгсөн мэдээллийн бүртгэлийг хөтөлж ажилласан байна.

ЦЕГ-ын www.police.gov.mn сайтад 12, аймгийн Цагдаагийн газрын www.bayan-ulgii.police.gov.mn сайтад 52 удаа мэдээ, мэдээлэл байршуулж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар радиогоор 39 удаа буюу 183 минут, орон нутгийн телевизийн сувгаар 99 удаа буюу 424 минут, сонин хэвлэлээр 2 удаа нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд түгээж ажилласан байна.

Цагдаагийн газар 2016 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1180 санамж, сэрэмжлүүлэг, 1590 зөвлөмж, 250 зурагт хуудсыг хэвлүүлэн, иргэд, олон нийтэд тарааж, аймгийн төв талбайд байршуулсан LED дэлгэцээр дамжуулан шторк, нэвтрүүлэг 3 удаа гаргаж, сурталчилжээ.

2017 онд ГХУСАЗСЗ, ЗДТГ, Цагдаагийн газар хамтран “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль”, аймгийн ИТХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Алтанцөгц, Бугат, Баяннуур сумдын удирдлагуудыг хамруулсан “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нь” сэдэвт хамтарсан зөвлөгөөнийг Алтанцөгц сумын төвд 2017 оны 03 сард зохион байгуулсан байна.

Цагдаагийн газар нь аймгийн ИТХурал болон аймгийн засаг даргад иргэд олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хуулиа дээдлэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй, ур чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоож, арилгах ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Хуулиа дээдлье” аяныг аймгийн хэмжээнд нэг жилийн хугацаатай зохион байгуулах талаар санал хүргүүлсэн байна.

Аймгийн удирдлага саналыг дэмжиж, аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаартай захирамжаар “Хуулиа дээдлье” ерөнхий арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Ажлын хэсгээс боловсруулсан 27 зүйл заалт бүхий ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн 4 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан

байна.Энэхүү арга хэмжээг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллаж байгаа ба төлөвлөгөөний биелэлт 70 хувьтай байна.

Аяны хүрээнд “Хуулиа дээдлэе” тугийг 2017 оны 3-5 дугаар саруудад аймгийн төв, сумын төрийн болон төрийн бус томоохон байгууллагуудад 40 хоногийн хугацаатай аялуулж, энэхүү хугацаанд тухайн байгууллагаас хууль тогтоомжийг сурталчлан таниулах, байгууллага дотооддоо гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдэгдэж болох шалтгаан нөхцөлийг арилгах ажлуудыг зохион байгуулжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хулгайлах, хүний эрүүл мэндэд санаатай хохирол учруулах, автотээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралт өссөн тодорхой багийн нутаг дэвсгэрт эргүүлийн олон хэлбэрийг зөв оновчтой зохион байгуулах зорилгоор 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2017 оны 10 дугаар сарын 01-ний хооронд аймгийн төвд “Оюутан цагдаа”, “Морьт эргүүл”, нисдэг камерийг ашиглаж “Эргүүл” хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулсан байна.

Дүгнэлт:

1.Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.

- 1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцөлийг тогтоох чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.
- 1.2 Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.
- 1.3 Захиргааны хяналтыг хуульд заасан журмын дагуу тогтоож, үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
- 1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэхэд ажлаа чиглүүлж, ач холбогдол өгч ажилласан байна.
- 1.5 Хууль сахиулах байгууллагууд хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэх, сурталчлах, сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан байна.

Бүлэг 2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байна.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байгаа эсэх талаар

ГХУСТХ-ийн 16.1-д:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн даргаар толгойлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөл зохицуулна гэж заасан.

2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэх талаар

ГХУСТХ-ийн 16.1-д заасны дагуу аймгийн ИТХ-ын дэргэд ИТХ-ын даргаар толгойлуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус зохицуулах зөвлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

2016 онд аймгийн ГХУСАЗСЗ-ийг шинэчлэн байгуулсан байна. Зөвлөлийн даргаар аймгийн ИТХ-ын дарга, зөвлөлийн орлогч даргаар аймгийн Засаг дарга, гишүүдээр аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч, аймгийн Прокурор, аймаг дахь Тагнуулын албаны дарга, Цагдаагийн газрын дарга, МХГ-ын дарга, Хилийн цэргийн 0165, 0285 дугаар ангиудын захирагч, Өлгий сумын ИТХ-ын дарга, Өлгий сумын Засаг дарга, БСУГазрын дарга, Гэр бүл Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газрын дарга, ГХУСАЗСЗ-ийн ажилтан гэсэн 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

ГХУСТХ-ийн 16.2-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны 150 тоот тогтоолоор аймгийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл”-ийн ажиллах журмыг 9 бүлэг, 48 зүйл заалтай баталсан байна.

Орон тооны бус зохицуулах зөвлөл нь харьяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлдэг байна.

Тус аймаг нь 13 сум, 1 тосгонтой бөгөөд 13 сумын 13 салбар зөвлөлд 144 гишүүн ажиллаж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2017 оны эхний хагас жилийн байдлаар 2 удаа хуралдаж, 5 удаа зөвлөгөөн зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах, хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээ, орон нутгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, хүндрэл бэрхшээл, алдаа дутагдал, шийдвэрлэх арга зам, шийдвэрлүүлэх асуудал, санал, зөвлөмж гаргаж ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл аймгийн Засаг дарга болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг улирал тутам гаргуулан биелэлтийг тооцож ажиллажээ. Тухайлбал:

Аймгийн ИТХурал, аймгийн ЗДТГазар, аймгийн Прокурорын газар, аймгийн Шүүх, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, ГБХЗХГ, сумдын салбар зөвлөлүүдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг авч нэгтгэн тайлагнаж, дүгнэж ажилласан байна.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөлийн бүрэлдэхүүн нь зөвлөлөөс баталсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах ажлыг хариуцан, Хууль сахиулах байгууллагуудтай хамтран сумдын салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2017 оны эхний хагас жилийн ажлын тайланг хэлэлцэж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаархи төрийн бодлого болон Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар өнөөгийн нөхцөлд тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлж санал гаргасан байна. Үүнд:

-Хууль зүйн салбарын шинэтгэлийн хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулагдсан хуулиуд, тэдгээрийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлын явцын талаар албан хаагч нарт сургалт зохион байгуулах, ард иргэдэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх,

-Мэргэжлийн судлаач, эрдэмтдийг оролцуулан олон улсын туршлагаас жишиг авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн найруулах,

-Иргэдээс гэмт хэргийн мэдээллийг төлбөртэйгээр худалдан авах асуудлыг илүү боловсронгуй болгох, улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх зэрэг асуудал тусгасан байна.

Үүнээс үзэхэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байгаа нь харагдаж байна.

2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүргүүд байгаа эсэх талаар.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь 2015, 2016 онуудад ХЗДХЯ-ны Бодлогын Хэрэгжилтийг Зохицуулах Газарт ажлаа хагас, бүтэн жилээр тайлагнаж байсан боловч ажлын үр дүнг дүгнэж, хариу үүрэг даалгавар, ажлын чиглэл өгч байгаагүй байна.

2017 оноос ХЗДХЯ-ны ГХУСАЗС-д урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, мэдээг батлагдсан тайлангийн загварын дагуу гаргаж өгдөг болсон байна.

ХЗДХЯ-ны ГХУСАЗСЗөвлөлөөс 2017 онд 1-1/159, 7/1964, 7/1981 тоот албан бичгүүдээр аймаг дахь салбар зөвлөлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ажлын чиглэл, зөвлөмж, үүрэг даалгавар өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд аймаг дахь хууль сахиулах байгууллага, мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагууд болон ТББ-уудын удирдлагыг оруулж ажиллуулсан нь гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх талаар эдгээр байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулахад ихээхэн ач холбогдолтой болсон байна.

ГХУСАЗСЗ-д Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцөл байдлын талаархи статистик мэдээг сар бүр гаргаж ирүүлж, мэдээлэл солилцож ажилласан байна.

Цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Цагдаагийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсэгт “Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна” гэж заасны дагуу тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласан байна.

ГХУСТХ-ийн 9 дүгээр зүйлд заасан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх аж ахуйн нэгж байгууллагын нийтлэг үүрэг”-ийн хэрэгжилтийг аж ахуйн нэгж байгууллагууд харилцан адилгүй хэрэгжүүлдэг байна.

Цагдаагийн газраас аудитын асуудалтай холбогдуулан цаашид төрийн байгууллагуудын зүгээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, байгууллагуудын уялдаа холбоог хангах, хууль сахиулах байгууллагын зохион байгуулж байгаа аливаа ажил, арга хэмжээнд оролцох, үүнд Цагдаагийн байгууллагаас хяналт тавих арга хэлбэрийг тодорхой болгох шаардлагатай байна гэсэн санал ирүүлсэнийг анхаарах нь зүйтэй байна.

Хууль сахиулах байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүрэг байгаа эсэх талаар санал авахад орхигдуулсан, давхардсан чиг үүрэг байхгүй гэсэн санал ирүүлсэн байна.

2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэх талаар.

Аймгийн ГХУСАЗСЗ, Прокурорын газрын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу жил бүр 5-6 сумын ГХУСАЗСЗ-ийн ажлыг шалгаж, үүрэг даалгавар, чиглэл өгч ажилласан байна. Шалгалтын дүнгээс үзэхэд:

Алтанцөгц, Баянуур сумуудын ГХУСАЗСЗ-ийн 2015 он болон 2016 оны 1-р улиралд хийсэн ажлыг шалгахад Алтанцөгц сумын салбар зөвлөл нь ГХУС ажлын чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гаргаагүй, бодитой ажил хийгээгүй байжээ.

Баяннуур сумын ГХУСАЗСЗ-өөс 2015 онд 10 ажил төлөвлөсний 7 нь малын хулгайтай тэмцэх асуудал байсан бол 2016 онд ямар нэг ажил төлөвлөж хэрэгжүүлээгүй байна.

Улаанхус сумын ГХУСАЗСЗ нь 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 26 ажил төлөвлөснөөс биелэлтийг шалгахад биелэлтийг тооцсон нотлох баримтгүй байжээ.

Ногооннуур сумын салбар зөвлөл нь 3 удаа малын хулгайтай тэмцэх чиглэлээр иргэдтэй уулзалт ярилцлага хийсэнээс өөр бодитой ажил хийгээгүй, 18 ажил төлөвлөснөөс, биелэлтийг тооцсоныг нотлох баримтгүй байсан байна.

Шалгалын дүнгээр дээрх сумдын ГХУСАЗСЗ-ийн ажлыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулах, зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулсан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-д сумуудын ГХУСАЗСЗөвлөлүүд 2015-2017 онд хийсэн ажлын тайлан, мэдээгээ ирүүлээгүй байна.

Дээрх байдлаас үзэхэд сумдын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааг сайжруулах, үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд санхүүгийн болон арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт:

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байна.

2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байна.

2.2 Төрийн байгууллагуудын уялдаа холбоо болон давхардсан, орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.

2.3 Сумуудын ГХУСАЗСЗ-үүдийн үйл ажиллагаа хангалтгүй хэрэгжсэн байна.

Бүлэг 3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөөс 23,9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэх талаар.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д “Нутгийн захиргааны бүх шатны байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:”,

- 7.6.2-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх”,
- 7.6.3-д “хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин туслах”,
- 7.7 “Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар харьяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан батална”

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилтийн талаар:

- 19.1-д “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан.

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө хуульд заасан хэмжээнд төлөвлөгдөж байгаа эсэх талаар.

Аймгийн ИТХ-аас ГХУС зардалд 2015-2017 онуудад жил бүр тодорхой хэмжээний хөрөнгийг орон нутгийн төсөвт тусган баталж ирсэн байна.Үүнд:

- 2015 онд 20,0 сая төгрөг
- 2016 онд 20,0 сая төгрөг
- 2017 онд 20,0 сая төгрөг тус тус баталсан байна.

Харин сумуудын ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаанд 2015 оноос хойш хөрөнгө төсөвлөж батлаагүй байна.

ГХУСТХуулийн 19.1-д заасан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлогыг сүүлийн гурван жилийн байдлаар судалж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №3 /сая төгрөгөөр/				
№	Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого	2015 он	2016 он	2017.06.30 байдлаар
1	Замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийн торгуулийн орлого	98.9	251.9	157.3
2	ШШГА-ны торгуулийн орлого	6.1	0.3	3.3
	Нийт дүн	105.0	252.2	160.6

Дээрх орлогын 40 хувийг тооцож үзэхэд:

- 2015 онд 42,0 сая төгрөг,
- 2016 онд 100,9 сая төгрөг,
- 2017 онд 64,2 сая төгрөг байна.

Үүнээс үзэхэд тус аймагт ГХУС ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хэмжээг хуулинд заасан хэмжээнд хүргэж төлөвлөгдөөгүй байна гэж үзэх үндэстэй байна.

3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт холбогдох хуулиудад нийцэж байгаа эсэх талаар.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.6.2-т заасны дагуу аймгийн ИТХурал ГХУС зардлыг өөрийн төсөвтөө тусгайлан төлөвлөж, санхүүжүүлж ирсэн байна.

ГХУС арга хэмжээнд батлагдсан зардлын зарцуулалтын гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт №4 /сая төгрөгөөр/				
№	Зардал	2015 он	2016 он	2017.06.30 байдлаар
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
1	Цалин, НДШ, томилолт	1.4	9.9	4.7
2	Гэмт хэргийн арга хэмжээнд	10.8	3.7	3.8
3	Аймгийн ИТхурлын үйл ажиллагаанд	0.9	6.3	0.8
4	Төсөвт төвлөрүүлсэн	6.1		
	Бүгд	19.2	19.9	9.3

Харин Аймгийн ИТХурлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд баталсан төсвийг ГХУСАЗСЗ нь ГХУСТХуулийн 19.3-т заасан зориулалтаар нь зөвлөлийн хурлаар хэлэлцэж батлаагүй байна.

ГХУС ажил, арга хэмжээний зардлыг ГХУСТХуулийн 19.3-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараахь чиглэлээр зарцуулна” гэж заасан.Тухайлбал:

19.3.1. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах байгууллага, төрийн бус байгууллагуудаас иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх;

19.3.2. энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах;

19.3.3. энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах;

19.3.4. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;

19.3.5. цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх;

19.3.6. гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай цагдаагийн байгууллага иргэдээс мэдээлэл авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх.

Аймгийн ИТХ-аас ГХУС зардалд 2015-2017 онд баталсан төсөв нь хуулийн 19.3-д заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 6 төрлийн арга хэмжээнд төлөвлөгдөөгүй, ГХУСТХуулийн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байгаа эсэх талаар.

ГХУС ажиллагаанд зарцуулсан төсвийн хөрөнгийн санхүүгийн анхан шатны баримтуудыг үндэслэн шалгаж үзэхэд:

-2015 онд 20,0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 19,2 сая төгрөгийн санхүүжилтийг авч 13,0 сая төгрөгийг зарцуулж, 6,1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Гүйцэтгэлийг шалгаж үзэхэд ГХУС арга хэмжээнд 8,6 сая төгрөгийг, олон нийтийн цагдаагийн ажилтаны урамшуулал, цалинд 2,2 сая төгрөгийг бүгд 10,8 сая төгрөгийг хуулинд заасны дагуу зарцуулж, ИТХ-ын үйл ажиллагаанд 2,2 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

-2016 онд 20,0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, гүйцэтгэлээр 20,0 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулжээ.ГХУС арга хэмжээний зардалд 3,7 сая төгрөгийг хуулинд заасны дагуу зарцуулж, ГХУСАЗСЗ-ийн ажилтаны цалин, НДШ, томилолтын зардалд 9,9 сая төгрөгийг, ИТХ-ын үйл ажиллагаанд 6,3 сая төгрөгийг бүгд 16,3 сая төгрөгийг зориулалт бус зарцуулжээ.

-2017 онд 20,0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас эхний хагас жилийн байдлаар 10,0 сая төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 9,3 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд ГХУС арга хэмжээнд 3,8 сая төгрөгийг хуулинд заасны дагуу зарцуулж, ГХУСАЗСЗ-ийн ажилтаны цалин, НДШ, томилолтын зардалд 4,7 сая төгрөгийг, ИТХ-ын үйл ажиллагаанд 0,8 сая төгрөгийг бүгд 5,5 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

ГХУСАЗСЗ-ийн ажилтаны орон тоо, цалингийн зардлыг орон нутгийн төсөвт хэрхэн төлөвлөж, тусгаж ирсэнийг тодруулж, судалж үзэхэд:

ГХУСАЗСЗ-ийн ажилтаны орон тоо 2011-2013 онуудад аймгийн ИТХ-ын орон тоонд багтаж төлөвлөгөөнд тусгагдаж ирсэн бөгөөд 2014 оноос аймгийн ИТХуралд 1 жолооч, 1 мэргэжилтэн 2 орон тоог нэмж авснаар ГХУСАЗСЗ-ийн ажилтаны орон тоог хасч баталсан байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн ажилтаны цалинг 2015 он хүртэл аймгийн ИТХ-ын төсвөөс, 2016 оноос хойш ГХУС арга хэмжээнд батлагдсан төсвөөс олгож ирсэн байна.

Аудитын дүнгээр аймгийн ГХУСАЗСЗ-ийн мэргэжилтний орон тоо, цалингийн зардлыг аймгийн ИТХ-ын төсөвт тусгаж батлах талаар албан шаардлага өгөв.

3.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хэрхэн явагдаж байгаа талаар.

ГХУС арга хэмжээний зардлыг аймгийн ИТХурлын төсөвт суулгаж, зарцуулалтыг тайлагнаж ирсэн. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээг санхүүжүүлэхдээ гүйцэтгэлийг хянаж олгосон байна.

2015 онд ГХУС арга хэмжээний зардлаас 6,1 сая төгрөгийг зарцуулаагүй төсөвт буцаан төвлөрүүлсэн, ГХУС арга хэмжээнд батлагдсан төсвийн хөрөнгөнөөс 2015-2017 онд нийтдээ 23,9 төгрөгийг зориулалт бус зарцуулсан зэргээс үзэхэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар санаачлага гаргаагүй, дотоодын хяналт хангалтгүй хэрэгжсэн байна үзэх үндэстэй байна.

ГХУСТХуулийн 19.5-д “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хяналт тавина” гэсэн хуулийн заалтыг аймгийн ИТХурал хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын дүнгээр аймгийн ИТХурлын ГХУСАЗСЗ-ийн ажлыг хариуцсан мэргэжилтэний цалин, НДШ, томилолтын зардалд 2016-2017 онд 14,6 сая төгрөгийг, аймгийн ИТХурлын үйл ажиллагааны зардалд 2015-2017 онуудад 9,3 сая төгрөгийг нийтдээ 23,9 төгрөгийг зориулалт бус зарцуулсан зөрчил нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно”, 19.5-т “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн төлөөлөгчдийн хурал хяналт тавина”,

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудыг зөрчиж байгаа тул Аймгийн ИТХурал, ГХУСАЗСЗ-д зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөв.

Мөн аймгийн ИТХ-ын даргад ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагааны талаар 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

Дүгнэлт:

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөөс 23,9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгө хуулинд заасан хувь хэмжээнд төлөвлөгдөөгүй байна.

3.2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд батлагдсан төсөв нь ГХУСТХуулийн 19.3-т заасан заалтуудтай нийцэхгүй байна.

3.3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгөөс 23,9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

3.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байна.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвөөс 23,9 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХурлын дарга, ГХУСАЗЗ-ийн дарга Д.Бауыржан танаа:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг ГХУСТХуулийн 19.1-д заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж, батлах.
2. Аймгийн ИТХурлаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд баталсан төсвийг ГХУСАЗСЗөвлөлийн хурлаар хэлэлцэж ГХУСТХуулийн 19.3-т заасан зардлын зүйл ангиар төлөвлөж, батлаж байх.
3. Сумуудын ГХУСАЗСЗөвлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх.

Байгууллагын санал

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН:

Дарга, тэргүүлэх аудитор

М.Хуанган

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Аудитын менежер

Х.Женисбек

ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН :

Аудитор

Д.Назгүл

Аудитор

Б.Үүрийнтуяа